



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаатай
холбоотой зарим журмуудад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4, 9.2.6, 15 дугаар зүйлийн 15.3, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтууд, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.26 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.
 - 1) Журмын 2.6 дахь хэсэгт “Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний 50 буюу түүнээс дээш хэмжээний багцыг их хэмжээний багцад тооцно.” гэснийг хасах;
 - 2) Журмын 4.2 дахь хэсгийг “Худалдагч эсхүл түүний брокер нь Биржээр арилжаалах бүтээгдэхүүний захиалгыг дараах баримт бичгийн хамт арилжаа зохион байгуулагдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө Биржид ирүүлнэ. Үүнд:” гэж өөрчлөх;
 - 3) Журмын 4.8 дахь хэсгийг “Худалдах захиалга нь энэхүү журамд заасан шаардлагыг хангасан тохиолдолд Биржийн Гүйцэтгэх захирлын тушаалаар бүртгэж, арилжааны зарыг олон нийтэд арилжаа зохион байгуулагдах өдрөөс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө Биржийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.” гэж өөрчлөх;
 - 4) Журмын 4.13 дахь хэсгийг “Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буурсан эсхүл өссөн тохиолдолд арилжаа зохион байгуулагдахаас ажлын 1-ээс доошгүй өдрийн өмнө дуудах доод үнийг өөрчлөх хүсэлт ирүүлж болно.” гэж өөрчлөх;
 - 5) Журмын 4.19.5 дахь заалтад “Биржээс мэдээлсэн арилжаа болон худалдах захиалгатай холбоотой мэдээ, мэдээлэлтэй Биржийн цахим хуудсаар дамжуулан тогтмол танилцах;” гэж нэмэх;
 - 6) Журмын Хавсралт 6-г “2.Эрчим хүчний нүүрсний үнийн индексийн хөдөлгөөнийг тооцох эрчим хүчний үнийн сагс”-ыг нэмж тусгасан байдлаар Хавсралтад зааснаар өөрчлөх.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам”-д дараах өөрчлөлтийг оруулсугай.

1525010110

- 1) Журмын 3.1 дэх хэсгийг “Худалдан авагчийн байршуулах дэнчингийн хэмжээ нь спот, форвард арилжааны хувьд уул уурхайн бүтээгдэхүүний доод үнээр илэрхийлсэн худалдах захиалгын нийт үнийн дүнгийн 10 хувь, брокероор дамжуулан арилжаанд оролцох тохиолдолд 5 хувьтай тэнцүү байна. Хэрэв Биржид бүртгэгдсэн худалдах захиалгад өөрчлөлт орж, дуудах доод үнэ өссөн тохиолдолд Худалдан авагч нь дэнчинг нэмж байршуулах шаардлагагүй.” гэх өөрчлөх;
3. Энэхүү тогтоолоор баталсан “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын нэмэлт, өөрчлөлт, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам”-ын өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, дагаж мөрдөх зөвшөөрөл авахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү журмуудын нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрсөн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

“Арилжааны журам”-д өөрчлөлт оруулах тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1, 47.2.2, 49 дүгээр зүйлийн 49.1.4, 49.3, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтууд, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.22 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Арилжааны журам”-д дараах өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:
 - 1) Хавсралт 1-ийн 4-т “Анхдагч зах зээл дээр компанийн бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдсан талаас 0.1575 хувь, худалдан авсан талаас 0.0175 хувийн,” гэснийг “Анхдагч зах зээл дээр компанийн бонд худалдсан талаас 0.0157 хувь, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдсан талаас 0.0787 хувь, компанийн бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авсан талаас 0.0175 хувийн,” болгон өөрчлөх.
2. Энэхүү тогтоолоор баталсан “Арилжааны журам”-ын өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, батламжлуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү журмын өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хорооноос батламжилсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525010114